



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Захиргааны эрх зүйн маргаан¹)

ХУВИЙН ӨМЧИЙН ЕБС-ИЙН ТӨГСӨГЧИД ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГТ ХАМРАГДАХ БОЛОМЖГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2024/0065

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдөр

Шийдвэрийн төрөл: Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гаргасан гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч нь ерөнхий боловсролын “Олонлог” төв сургуулийг 2023 онд төгсөхдөө, ЭЕШ-д математик-800, англи хэл-800, физик-725 гэсэн оноо авсан ба их сургуульд суралцахдаа Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт хамрагдах гэсэн боловч “хамран сурах тойрог”-ийн сургуулийг төгсөөгүй гэсэн үндэслэлээр тэтгэлэгт хамруулаагүй байна. Улмаар нэхэмжлэгч “... хувийн сургуульд сурсан хүүхэд энэ тэтгэлэгт оролцох ямар ч боломжгүй болж, төгссөн сургуулиар нь ялгасан, зөвхөн төрийн өмчийн сургуульд сурсан хүүхдэд тэтгэлэг олгож, тэгш бус хандсан ...” гэж шүүхэд марган, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх хэсгийн “...хамран сургах тойргийн дагуу ...” гэсэн хэсгийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасан байна.

Харин хариуцагч Засгийн газрын зүгээс “сум, хороо бүрээс нэг суралцагчийг шалгаруулах ерөнхий шалгуур тавьсан. Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг нь гадаадад өөрийн төлбөрөөр суралцах боломжгүй, төрийн өмчийн сургуульд сурлагын амжилт гаргасан, харьяа сум, хороондоо суралцаж буй суралцагчийг дэмжих зорилготой тэтгэлэг юм. Хувийн болон төрийн өмчийн сургуулиудын хөтөлбөр, багц цаг, агуулга харилцан адилгүй тул шалгуур тавих нь Засгийн газрын бүрэн эрхийн асуудал” гэж маргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Давж заалдах шатны шүүхээс:** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэж², дараах үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Үүнд:

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3265?daterange=2024-01-01%20-%202025-06-26&id=3&court_cat=3&bb=1.

² ЗХШХШТХ (2016)-ийн 112 дугаар зүйлийн 112.1-т “Дараахь төрлийн маргааныг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ:” гээд 112.1.1-т “улсын хэмжээний, эсхүл хоёр болон түүнээс дээш засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд үйлчлэх захиргааны хэм хэмжээний акттай холбоотой маргаан;” гэжээ.



2. Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийн сонгон шалгаруулалт нь бэлтгэл хөтөлбөрт болон тэтгэлэгт хөтөлбөрт тус тус сонгон шалгаруулах гэсэн 2 үе шаттай. Маргаан бүхий журмын 3.2.1 нь бэлтгэл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад хамрагдагсдад хамааралтай. Өөрөөр хэлбэл журмын шаардлага нь зөвхөн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд л хамааралтай, **хувийн сургууль төгсөгчид бэлтгэл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй.**
3. Төгссөн сургуулиас нь хамаарч ялгамжтай журамласнаар Монгол Улсын Үндсэн хуулийн ... ялгаварлан гадуурхаж үл болно гэж заасныг зөрчсөн эсэх, өөрөөр хэлбэл, Засгийн газрын тогтоол Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэхэд тус шүүх дүгнэлт өгөх эрхгүй.
4. “Тэгш боломж”-ийг зөвхөн тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт хамрагдагсдад хамран сургах **тойргийн буюу төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн төгсөгч байхаар**, сургалтын амжилт гаргасан ч цаашид өөрсдийн зардлаар суралцах боломжгүй, тодруулбал нийгмийн зорилтот бүлэгт илүүтэй чиглэх зорилгоор журамласны улмаас нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн гэж үзэхгүй.
5. Нэхэмжлэгч заавал Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт бус Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт, эсхүл Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын дагуу төрөөс олгох санхүүгийн дэмжлэгт тус тус хамрагдах боломжтой.
6. **Нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэл:** Өмгөөлөгч давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг ЗХШХШТХ-ийн 123 дугаар зүйлийн 123.2.1-т заасан үндэслэлээр эс зөвшөөрч, “Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг нь сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан бүх суралцагчид зориулагдсан бөгөөд зөвхөн төрийн өмчийн сургуульд суралцагчдад олгохоор хуульчлаагүй. Суралцагчдад шударга өрсөлдөөн бүхий санхүүгийн дэмжлэг үзүүлэх ёстой атал төгссөн сургуулиар нь ялгаварласан нь хууль зөрчсөн. Засгийн газрын журам нь сум, хорооны төлөөллийг жигд хангах зорилготой нийцээгүй бөгөөд шүүх ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлсэн шийдвэр гаргасан” гэжээ.
7. **Хяналтын шатны шүүхээс:** Төрөөс олгож буй аливаа **санхүүгийн дэмжлэг, тусламж нь тодорхой болзол шалгуур хангасан тохиолдолд олгогдох нөхцөлтэй байгааг “тэгш эрхийн зарчим зөрчсөн” гэж үзэхгүй**, тусламж дэмжлэг олгох шалгуур нөхцөлүүд нь төрийн бодлогыг илэрхийлэх бөгөөд нийгмийн нэг бүлэгт чиглэсэн, эсхүл тухайн бүлэг дотор дахин шалгуур нөхцөл тавьж хэсэг этгээдэд чиглүүлэх боломжтой, үүнийг шүүх “хууль бус” гэж дүгнэх боломжгүй. (12)³
8. Нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан “... Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүйгээс гадна Боловсролын тухай (2002 оны) хуулийн 5 дугаар зүйлд заасан боловсролын үндсэн зарчмуудын нэг болох 5.1.4-д “иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс,

³ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана” гэж заасныг зөрчиж байгаа” гэх гомдол үндэслэлгүй. (12)

9. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар зарлигаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг олгохтой холбоотой асуудлаар Засгийн газарт чиглэл өгөхдөө “сум, хороо бүрийн төлөөллийг жигд хангах” агуулгыг тусгайлан дурдсан, сум хороо бүрийн төлөөллийг жигд хангах объектив шалгуур болгож тухайн баг, сум, хороог хамран сургах **тойргийн сургуульд суралцагсдаас сонгон шалгаруулахаар журамласан** нь энэ тохиолдолд “зорилгодоо нийцсэн.” (13)
10. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгийг “**сүүлийн 3-аас доошгүй жил ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийн дагуу харьяалагдах сум, хороондоо суралцан төгссөн байх**” шаардлагыг хангасан иргэнд олгохоор нөхцөл болзол тавьсан нь **өөрийн амьдардаг баг, хорооны нутаг дэвсгэрийн харьяалах ерөнхий боловсролын сургуульд суралцагсдад чиглэсэн**, тэдгээрт төрөөс санхүүгийн дэмжлэг, тусламж олгох зорилготой байх бөгөөд төрөөс ийм бодлого баримталсныг “буруу” гэх, “бүгдэд нээлттэй байх ёстой” гэх хууль зүйн үндэслэлгүй. (14)
11. Давж заалдах шатны шүүх “Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэхэд тус шүүх дүгнэлт өгөх эрхгүй” гэж буруу дүгнэлт хийсэн, нэхэмжлэгчээс ердийн хууль буюу Боловсролын хуулийн тодорхой заалтыг нэрлэн зааж, тэгш эрхийн зарчим зөрчсөн гэж маргаж байхад үүнийг Үндсэн хуулийн эрх зүйн маргаан гэж үзэхгүй, захиргааны хэргийн шүүх энэ асуудлаар бүрэн дүгнэлт хийж хэргийг шийдвэрлэх боломжтой. (16)
12. Дээрх үндэслэлээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.